УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2021 оны 08 сарын 24 өдөр Дугаар А/207 Улаанбаатар хот

Мах, махан бүтээгдэхүүнийг бөөнөөр
худалдаалах байршил тогтоох
тухай

Хүнсний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Эрүүл ахуйн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, 20 дугаар зүйлийн 20.5, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/588 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.6, 4 дүгээр хэсгийн 4.6.1, 4.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мал, амьтны гаралтай мах, махан бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалахгүй байх зорилгоор эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлага хангасан, дотор орчинд мах, махан бүтээгдэхүүнийг бөөнөөр худалдаалах зах, худалдааны төвүүд болон мах нийлүүлэх аймгуудын хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх авто товчоогоор ирж буй мах ачсан тээврийн хэрэгслийг саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэхийг нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал), аймаг орон нутгийн мэргэжлийн нэгжээр дамжуулан зах, худалдааны төвүүдэд хуваарийн дагуу мах нийлүүлэх, хүлээн авахад нэгдсэн хяналт тавьж, зохион байгуулахыг нийлэлийн Мал эмнэлгийн газар (А.Нарантуяа), нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Д.Баянбат), хяналт шалгалт зохион байгуулахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (С.Даваасүрэн), дүүргийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг тус албаны Хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтэс /Т.Золжаргал/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

C:\Users\Gantuya\Desktop\ҮЖ 12\doc 2021\тушаал 2_.docx

1110300655

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
А/207 дугаар тушаалын хавсралт

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БӨӨНӨӨР ХУДАЛДААЛАХ БАЙРШИЛ,
МАХ НИЙЛҮҮЛЭХ АЙМГИЙН ХУВААРЬ

№	Зах, худалдааны төвийн нэр	Байршил, регистрийн дугаар	Шалган нэвтрүүлэх авто товчоо	Мах хүлээн авах аймаг
1	"Хүчит шонхор" ХХК-ийн Шонхор зах	ЧД, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000, /2019493/	Сонгинохайрхан дүүрэг, Шар хөтөл	Хөвсгөл, Ховд, Увс, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Говь-Алтай
2	"АНКО" ХХК-ийн Нарантуул - 2 зах	ЧД, 12 дугаар хороо, Дэнжийн 1000, /2549026/		Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Сэлэнгэ, Төв, Улаанбаатар
3	"Хархорин хүрээ" ХХК-ийн Хархорин худалдааны төв	БГД, 20-р хороо, /2794365/		Завхан, Булган
4	"Мөнгөт цахир трейд" ХХК-ийн Нарлаг дэнж худалдааны төв	ЧД, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000,	Багануур дүүрэг, Хэрлэнгийн гүүр, Хан-Уул дүүрэг, Өлзийт, Таван толгой	Хэнтий
5	"Баатрууд тэнгэр" ХХК-ийн Тэнгэр плаза ХТ	БЗД-ийн 8-р хороо Улаан хуаран гудамж 30/02 тоот /5755085/		Сүхбаатар, Говьсүмбэр, Дорнод
6	"Эко могул" ХХК-ийн Амгалан зах	БЗД-ийн 10-р хороо, /5397138/		Говьсүмбэр, Дундговь, Дорноговь
7	"Комит сервис" ХХК-ийн Лавай ХТ	ХУД, 20-р хороо, /2734303/	Хан-Уул дүүрэг, Өлзийт, Таван толгой	Дундговь, Өмнөговь
8	"Дельта комплекс трейдинг" ХХК-ийн Монгол фармер ХТ	ХУД, 20-р хороо, Атар өргөө-ийн урд, /5368499/		Дундговь

Жич: Мал төхөөрөх цехээс нийлүүлэх махыг 2021 оны 11 дүгээр сараас эхлэн дээрх зах, худалдааны төвүүдэд хувиарлана.